

СҮХБААТАР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ДОТООД АУДИТЫН ТАСГИЙН 2023 ОНЫ ХИЙСЭН АЖЛЫН ИЛТГЭХ ХУУДАС

2024.01.10

Улаанбаатар хот

Нэг.Ерөнхий зүйл :

Тус тасаг нь Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээний стандарт, нийгмийн даатгалын ажилтны ёс зүйн дүрмийг мөрдлөг болгон үйлчилгээний соёл сахилга хариуцлагыг дээшлүүлэн ажиллалаа.

Тасаг болон байцаагч тус бүр 2022 оны ажлаа дүгнэн, 2023 онд хийх ажлыг жил улирлаар төлөвлөн төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээ байгуулан, ололт амжилтийг дүгнэн ажиллаж байна.

Нийгмийн даатгалын ажилтны ёс зүйг өдөр тутмын ажилдаа мөрдлөг болгон зөрчил дутагдал гаргалгүй, иргэд даатгуулагч, ажил олгогчдын эрэлт хүсэлтийг хүлээн авч, хуулийн хүрээнд шалган зааварчилж гомдол чирэгдэл гаргалгүй хугацаанд барагдууллаа.

Хоёр: 2023 онд хийхээр төлөвлөсөн ажлын гүйцэтгэлийн талаар:

2023 оны байдлаар нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилт, хөдөлмөрийн хөлсний сан түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлсон байдал, нийгмийн даатгалын шимтгэл хураамжийн ногдуулалт, төлөлт, тайланг хугацаанд нь тушааж буй байдлыг нийт 251 ажил олгогчийн 5093 даатгуулагчийг хамруулан, улсын байцаагчийн актаар 84 ажил олгогчид 200,2 сая төгрөгийн хөдөлмөр хөлс түүнтэй адилтгах орлогын төлбөр зөрчлийн дүнгээс 63,5 сая төгрөгийн шимтгэл нөхөн төлүүлж, түүнээс 116,4 сая төгрөгийн алданги ногдуулж нийт 179,9 сая төгрөгийн төлбөр зөрчлийн дүнг 100% хувь барагдуулаад байна.

Нийгмийн даатгалын шимтгэлээ хугацаанд нь төлдөггүй, тайланг хугацаандаа тайлагнаагүй даатгуулагчийн эрх ашгийг хохироосон нийт 135 ажил олгогч байгууллагын захирал, нягтлан бодогчдод Зөрчилын тухай хуулийн 10.17 дугаар зүйлийн 10.17.1, 10.17.2, 10.17.3, 10.17.4, 10.17.5 заалтын дагуу шийтгэврийн хуудсаар 49,5 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан.

Дотоодын хяналт шалгалт хийх төлөвлөгөөт ажлын хүрээнд 2023 оны 09 дүгээр 01-ний өдрийг хүртэлх хугацаанд шинээр тогтоогдсон 745 өндөр насны тэтгэвэр авагчийн 724,7 сая төгрөг, тэжээгчээ алдсаны 51 тэтгэвэр авагчийн 27,6 сая төгрөг, тахир дутуугийн 214 тэтгэвэр авагчийн 117,5 сая төгрөг нийт 1010 тэтгэвэр авагчийн 869,9 сая төгрөгийн тэтгэврийн хувийн хэргийг шалгав. Үүнээс ажилласан хугацааг нотлох тушаалын хуулбар авах, сайн дурын даатгуулагчийн цуцласан гэрээг хавсаргах болон цалин буруу шивсэн, хувийн хэргийн хавтсанд хүлээж авсан материалын бүрдүүлэлтийг тэмдэглэдэггүй, ажилласан жил буруу тооцох зэрэг зөрчил гарсныг тухай бүр хариуцсан байцаагчаар нь засаж залруулан хянан шалгаж ажиллаж байна.

Мөн ХЧТА -8352 даатгуулагчийн 1857,1 сая төгрөгийн тэтгэмж, жирэмсний болон амаржсаны 3007 даатгуулагчийн 8327,7 сая төгрөгийн, YOMШӨ-н ХЧТА-71 даатгуулагчийн 77,6 сая төгрөгийн нийт 11430 даатгуулагчийн эмнэлгийн хуудасыг шалгаж 10262,5 сая төгрөгийн тэтгэмжийг хянаж олгуулав. Шалгах явцад цалингийн дундаж буруу тооцох, жирэмсэн болон амаржсаны тэтгэмжтэй байгаа даатгуулагчийн цалинд төрөл буруу сонгох, шимтгэл төлөхгүй байх зэрэг зөрчлүүд илэрч тухай бүрд засаж залруулан ажиллаа. Мөн хяналтын monitoring программаар тэтгэмжийн бодолтын мэдээлэлийн бааз дээр байгаа алдааг шалгаж тайлбар шалтгааныг нь байцаагч тус бүрээр бичиж хааж байгаа.

Тайлант хугацаанд 1869 даатгуулагчдын 3738,5 сая төгрөгийн оршуулгын тэтгэмжийн олголт бодолт болон ажилгүйдлийн даатгалын сангаас 1066 хүнд олгосон 4519,2 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжинд шалгаснаас ажилгүйдлийн тэтгэмж авах хугацаандаа ажил хийсэн, цалин буруу шивсэн, цалинг нэгдсэн мэдээллийн санд шивээгүй бодолт хийсэн, ажилласан жилийг нотлох баримт дутуу зэрэг зөрчлийг байсныг хариуцсан байцаагчаар тухай бүр нь засаж залруулав.

Дотоод хяналт шалгалтаар илрүүлсэн төлбөр зөрчил 2023 онд:

- Тэтгэмжийн даатгалын санд- 61 даатгуулагчийн 34,5 сая төгрөгийн төлбөрөөс 33,0 сая төгрөгийг төлүүлсэн.
- Тэтгэврийн даатгалын санд 2023 онд 25 тэтгэвэр авагчтай холбоотой 191,8 сая төгрөгийн төлбөр зөрчлөөс 151,2 сая төгрөгийн зөрчлийг барагдуулж, дутуу олгосон 2 тэтгэвэр авагчийн 17,1 сая төгрөгийн тэтгэврийг олгож ажиллаа. Нийт 82 иргэнтэй холбоотой 509,6 сая төгрөгийн төлбөр зөрчлөөс дүнгээс 254,7 сая төгрөгийн төлбөрийг барагдуулж, барагдаагүй төлбөр 254,9 сая төгрөгийн зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, мөн хуулийн дагуу 50% хүртэлх хэмжээгээр суутган төлүүлж ажилласан.

Нийгмийн даатгалын байгууллага нь шилэн дансны хуулийн дагуу энэ жилд үйл ажиллагааны санхүүгийн 20 төрлийн мэдээллийг тухай бүр, сар бүр, улирал бүр, хагас жил бүр, жил бүр гэсэн давтамжтайгаар нийт 69 удаа, Нийгмийн даатгалын сангийн шилэн дансны 21 төрлийн 75 мэдээллийг тухай бүр, сар бүр, улирал бүр, хагас жил бүр, жил бүр гэсэн давтамжтайгаар үнэн зөв, хуулийн хугацаанд нь бүрэн байршуулж байгаа эсэхэд сар бүр хяналт тавин ажилласан. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт тус тус цахимаар дараа сарын 8-ны дотор хавсралтанд заасан маягтын дагуу байршуулж байгаад хяналт тавьж ажиллаж байна.

Тус хэлтсийн дэргэдэх Эмнэлгийн хөдөлмөр магадлах комисс нь 10 хүний бүрэлдэхүүнтэйгээр хөдөлмөрийн чадвар алдсан хувь хэмжээ, хугацааг тогтоох, сунгах, цуцлах, хөдөлмөрийн нөхцөлийг өөрчлөх, ажлын цагийг богиносгох асуудлыг магадлан шийдвэрлэх чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж, тайлант хугацаанд 39 өдөр буюу 304 цаг хуралдаж, 385 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг шинээр тогтоох, 1326 хүний хувь хугацааг сунгах, дүрмийн дагуу хөдөлмөрийн чадвар алдалт тогтоох нөхцөл шаардлагыг хангахгүй 26 хүнийг материал нөхөн бүрдүүлэхээр, биеийн байдал сайжирсан, хяналтын хугацаа дууссан, өндөр насны тэтгэвэр тогтоолгох зэрэг шалтгаанаар 71 иргэний хувь хугацааг цуцлах байдлаар нийт 1782 даатгуулагчийн

асуудлыг шийдвэрлэж ирсэн байна. Тус комисс нь иргэний харьяаллын дагуу шилжиж ирсэн 66, шилжиж явсан 45 иргэний шилжилт хөдөлгөөнийг эмнэлэг хөдөлмөрийн магадлалын мэдээллийг санд цаг тухайд нь хийж ажиллав.

Тус дүүргийн нутаг дэвсгэрт үйлдвэрлэл үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагын нийгмийн даатгалд хамрагдсан байдалд үзлэг явуулах, нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, иргэдийн нийгмийн баталгааг хангах, нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, хамрах хүрээг өргөтгөх зорилтын дагуу ажиллаж тэдгээрийг шинээр хамруулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилган мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.

Гурав: Бусад

1. 2023.01.10-ны өдрийн Хэлтсийн даргын баталсан №01 тоот удирдамжийн дагуу “Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах” ажлын удирдамж дагуу 2020 оны 01 дүгээр сарын 01-нээс 2022 оны 12 дугаар сарын 31-ныг дуустлах хугацааны 5078 ажилгүйдлийн тэтгэмжийг 01.10-01.24 өдрийн хугацаанд шалгаж зөрчилтэй байж магадгүй 48 даатгуулагчийн жагсаалтыг ажилгүйдлийн тэтгэмжийн байцаагчид гарган өгсөн.
2. 2023 оны 03 дугаар сарын 14-ны өдрийн Хэлтсийн даргын баталсан №02 тоот “Аж ахуйн нэгж байгууллагын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг шалгах ажлын удирдамж”-н дагуу шалгасан. Нийт ажил олгогчийн массив- 9785, үйл ажиллагаа зогссон -2912, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан 6873 аж ахуй нэгж шалгасан.
 - Мэдээллийн баазаас 3-НД7, 3-НД8 тайлан зөрсөн-16,
 - Байгууллагын тамгагүй-893,
 - Байгууллагын дарга, нягтлан бодогчийн гарын үсэггүй-837,
 - Дутуу тайлан-16,
 - Нөхөнгийн тайлангийн албан бичиг баримт, цалин залруулгын баримт, карт зэрэг тайланд хавсаргаагүй-59,
 - Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн төрөл буруу тайлагнасан-1646 зөрчлийг шийдвэрлүүлэхээр Орлого шимтгэлийн тасгийн дарга Ё.Уранцэцэгт тоо дүнг өгсөн.
3. 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн Хэлтсийн даргын баталсан №03 тоот “Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг, шимтгэлийн хуримтлагдсан авлагыг барагдуулах ажлыг эрчимжүүлэх, хамралтыг нэмэгдүүлэх” ажлын удирдамжийн дагуу 121 хоногоос дээш шимтгэлийн хуримтлагдсан өртэй 792 аж ахуй нэгж байгууллагын 48,2 тэрбум төгрөгийн шимтгэлийг барагдуулах ажлыг 2023 оны 04 дүгээр сарын 01-ны өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг дуусталх хугацаанд барагдуулах ажлын удирдамжийн дагуу 2023 оны байдлаар шимтгэлийн хуримтлагдсан өртэй 633 байгууллагын 48,0 тэрбум төгрөгийн авлагаас 56,1 тэрбум төгрөгийн өрийн барагдуулж 45,9 тэрбум төгрөгийн урсгал авлага үүссэн байна.
 - Ж.Хүрэлчулуун, Ц.Мөнхцэцэг-129 аан-н 10.3 тэрбум төгрөгөөс 14,5 тэрбум төгрөг барагдуулсан боловч 11.4 тэрбум төгрөгийн урсгал өр үүссэн байна.

- Д.Энхтуяа, Б.Баянзул-141 аан-н 12.7 тэрбум төгрөгөөс 17.2 тэрбум төгрөг барагдуулсан боловч 8.2 тэрбум төгрөгийн урсгал өр үүссэн байна.
- Н.Гэрэлээ -179 аан-н 11.6 тэрбум төгрөгөөс 16.1 тэрбум төгрөг барагдуулсан боловч 10.9 тэрбум төгрөгийн урсгал өр үүссэн байна.
- У.Наранбаатар, Т.Цэрмаа 184 аан-н 13.4 тэрбум төгрөгөөс 8.3 тэрбум төгрөг барагдуулсан боловч 15.4 тэрбум төгрөгийн урсгал өр үүссэн байна.

4. 2023.09.08-ны өдрийн Хэлтсийн даргын баталсан №04 тоот удирдамжийн дагуу тэтгэвэр дагуу 2023 оны 04 дүгээр сарын 01-ны өдрөөс 09 дүгээр сарын 01-ны өдрийг хүртэлх хугацааны шинээр тогтоогдсон нийт 679 тэтгэвэр авагчийн хувийн хэрэг материалыг дахин хяналтаар оруулж шалгаж ажиллаа. Шалгалтаар гарсан зөрчлийг байцаагч бүрээр гаргаж өгч засаж байна.

5. 2023 оны 03 дугаар сарын 09-ны өдөр Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн “Урьдчилан сэргийлэх хяналт, шалгалт хийх нэгдсэн удирдамж”-н дагуу Сүхбаатар дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газраас 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар Нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр тогтоолгон авч байгаа 2355 иргэдийн судалгааг гаргуулж манай хэлтсийн 22014 тэтгэвэр авагчийн мэдээлэлтэй тулган шалгаж 7 иргэдийн 31,7 сая төгрөгийн төлбөр зөрчлийг гаргаж Нийгмийн даатгалын ерөнхий газар хүргүүлж Сүхбаатар дүүргийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газарт улсын байцаагчийн акт тавигдсан.

6. Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2021 оны 01 дугаар сарын 26-ны өдрийн 03/26, 2/520 тоот “Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай” албан тоот, “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хууль”-ийн хэрэгжилт, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дугаар хэсэгт заасан нөхцлөөр 2021 оныг хүртэлх хугацаанд шинээр тогтоолгосон өндөр нас авагчийн тэтгэврийн хувийн хэрэгт бүрдүүлсэн хөдөлмөрийн дэвтэр, нийгмийн даатгалын дэвтэр, тушаал, архивын лавлагаа, шүүхийн шийдвэр болон ажилласан жил нөхөн тооцуулахаар бүрдүүлсэн баримт анхан шатны баримт, цалингийн лавлагааны үндэслэл зэргийг архивын хянан шалгаж баталгаажуулах, илэрсэн дутагдлыг арилгаж ажиллаж байна. Шалгалтаар 1396 өндөр насны тэтгэвэр авагчийн тэтгэврийг шалгаж 47 тэтгэвэр авагчтай холбоотой 758,4 сая төгрөгийн төлбөр зөрчлөөс 42 тэтгэвэр авагчийн 633,5 сая төгрөгийн төлбөр зөрчлийг нотлон баталгаажуулж, 446,0 сая төгрөгийг төлүүлж үлдэгдэл 187,4 сая төгрөгийн төлбөрийг суутган тооцож барагдуулах ажил хийгдэж байна. Мөн 5 тэтгэвэр авагчийн 124,9 сая төгрөгийн төлбөр нотлогдоогүй, улсын байцаагчийн акттай 1 тэтгэвэр авагчийн 14,7 сая нийт 5 иргэний 139,6 сая төгрөгийн төлбөр зөрчлийг барагдуулахаар хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.

7. 2023 оны нийгмийн даатгалын хяналт шалгалтын тайлан дүн мэдээг улирал бүр заасан хугацаанд Нийслэлийн нийгмийн даатгалын газарт гарган өгч баталгаажуулж ажилласан.

8. 2023 онд ажил хөдөлмөр эрхлээгүй, хувиараа хөдөлмөр эрхлэгч 89 иргэдийг сайн дурын даатгалд хамруулсан, шинээр 36 аж ахуй нэгж байгууллага, албан журмын даатгуулагч 54 хамруулсан .

- 1) Виртаул дижитал принт ХХК-280010149
- 2) Интер блю ХХК-280009534
- 3) Авто прадайс ХХК-280009675
- 4) Цээс ХХК-280009767
- 5) Алтан нар ивээл трейд ХХК-280009857,
- 6) Маяа спорт вейс ХХК-280009675
- 7) Хутсай баяслаг ХХК-280009734
- 8) Буянт цонх ХХК-280009778
- 9) Түшиг өргөө ХХК-280009786
- 10) Легото мемд ХХК-280009915,
- 11) Арвижих fumo ХХК-280010007
- 12) Шин и илон ХХК-280010149
- 13) Эйс ти проперти менежмент ХХК-280009588
- 14) Мөнгөлөг улиас ХХК-280009739
- 15) И эл лимитэд ассет ХХК-280009886,
- 16) Арвижих амуудай ХХК-280010007
- 17) Мөнх батжилт цамхаг ХХК-280010090
- 18) Дү ит стар ХХК-280009514
- 19) Коко ланд ХХК-280009656
- 20) Ложин скилл ХХК-280009748,
- 21) Зенит солор ХХК-280009991
- 22) Анлимитед лайн ХХК-280010018
- 23) Холч мөр ХХК-280010045
- 24) Смарт лондри ХХК-280010198
- 25) Биг Монголиа ложистик ХХК-280009492
- 26) Од даръяа сан -280009643
- 27) Берил эс ди ди ХХК-280009713
- 28) Бичил эй би эс плас ТЗН-280009802
- 29) Морьтон гранд ББСБ-280009952
- 30) Цэцэг төв цэцэгтэй элч ХХК-280009963
- 31) Гэрэгэ моннел ХХК-280010073
- 32) Штиль хадс ХХК-280010247
- 33) Фүүрст спейс ХХК-280009618
- 34) Ганиш тревал Монголиа ХХК-280009793
- 35) Ашид бум дэлгэмэл ХХК-280009941
- 36) Арвин эхлэл пресс ХХК-280009816,

9. Зөрчлийн тухай хуулийн 10.17.1, 10.17.2, 10.17.4, 10.17.5 дугаар заалтын дагуу хялбаржуулсан журмаар 135 аж ахуй нэгж байгууллагад 39,2 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ ногдуулж СБД-н Прокурорын нэгдсэн бүртгэлд хугацаанд нь бүртгүүлж торгуулийг бүрэн барагдуулсан. Зөрчлийг хэрэг нээхээс татгалзсан тогтоол 34 байгууллагад гаргасан.

- 10.17.1-2 байгууллага -1.0 сая төгрөг
- 10.17.2-5 байгууллага-8.2 сая төгрөг
- 10.17.3-/3/ байгууллага-1,5 сая төгрөг-10.17.4-тэй хамт з/х үүссэн.
- 10.17.4-85 байгууллага-21,25 сая төгрөг
- 10.17.5-1 байгууллага- 5.0 сая төгрөг

нийт 36,9 сая төгрөгийн шийтгэлийн хуудсаар торгууль ногдуулсан.

- Зөрчлийн хэрэг нээхээс татгалзсан тогтоол 28 байгууллагад улсын байцаагчийн актаар 83 даатгуулагчдад 100,4 сая төгрөгийн цалингын сангаас 17,6 сая төгрөгийн шимтгэлийг тооцож 8,8 сая төгрөгийн алданги ногдуулж нийт 26,4 сая төгрөгийн төлбөр зөрчлийг 100% барагдуулсан.
- Орлого шимтгэлийн тасаг 10.17.4 дүгээр заалтаар 9 байгууллагад 2,25 сая төгрөгийн арга хэмжээ ногдуулж нийтдээ хэлтсийн хэмжээнд 135 байгууллагад 39,2 сая төгрөгийн төлбөр зөрчлийг ногдуулж ажилласан.

10. Сүхбаатар дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан иргэдийг угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, эрдэлээс хамгаалах ажлын хэсгийг Засаг даргын удирдамжаар 18 дугаар хорооны нутаг дэвсгэрт угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх чиглэлээр галлагааны буюу өвлийн улиралд төдийгүй хаврын улиралд ч байшингийн гадаад, дотоод агаарын температур ойртож, яндангийн таталт муудан угаартах магадлал ихэсдэг тул иргэдийг аливаа эрсдэлээс хамгаалах чиглэлээр зөвлөмж зааврыг өгч ажиллаа.

11. Сүхбаатар дүүргийн Засаг даргын захирамжаар 2023 оны 04 дүгээр сарын 28-ний өдөр 12 дугаар хорооны нутаг дэвсгэрийн Сэлбэ голын ойр орчим, 2023 оны 05 дугаар 26-ний өдөр 15 дугаар хорооны Дамбадаржаа дах жалганы хогийг цэвэрлэсэн.

Тайлангийн хугацаанд бусад ажлыг Монгол Улсын нийгмийн даатгалын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтүүд болон салбарын харилцааг зохицуулж буй эрх зүйн актуудыг хэрэгжүүлэх, байгууллагын үйл ажиллагааны хэвийн байдлыг хангах, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэхэд зохион байгууллалтын оновчтой хувилбараар ажиллахад гол анхаарлаа чиглүүлэн ажиллалаа.

Тайлангийн хугацаанд тус тасаг нь 1126 хүсэлт ирсэн. И-Док-д 1006 албан хүсэлт, 120 даатгуулагчийн нийгмийн даатгалын хуулийн хэрэгжилттэй холбоотой өргөдөл гомдол, хүсэлтийг хүлээн авч хүсэлт өргөдлийн дагуу хариуг нь хуулийн хугацаанд шийдвэрлэв.

- Зөрчлийн тухай хуулиар 135 аж ахуй нэгж байгууллага,
- Улсын байцаагчийн актаар байгууллага-75,
- Хяналт шалгалтын зөвлөмжөөр 42 байгууллага шийдвэрлэсэн.
- Хяналтын картаар анхан шатны санхүүгийн баримтыг хянаж нийгмийн даатгалын шимтгэл төлж ажилласан цалин, шимтгэл ногдуулсан төрөл хувь хэмжээг залруулах хүсэлт 724 байгууллагын материалыг хянаж Орлого шимтгэлийн тасагт өгч залруулсан.
- Бусад мэдээ судалгаа, дүүргүүдийн нийгмийн даатгалын байгууллагаас ирүүлсэн хүсэлт, хүсэлтийн хариу зэрэг 4 албан бичиг ирсэн.

Нийгмийн даатгалын хууль болон бусад хууль тогтоомжтой холбоотой асуудлаар хяналтын бүх байцаагч гарын авлага болон судалгаатай болж ажиллаж байна.

НДЕГ болон ННДГ, хэлтсээс зохион байгуулсан цаг үеийн шинжтэй бүх үйл ажиллагаанд идэвхитэй оролцож өгсөн үүрэг даалгаваруудыг тухай бүрт нь биелүүлж ажилласан.

Дөрөв: Дүгнэлт, зорилт

2023 онд олсон ололт амжилт, хүрсэн үр дүндээ тулгуурлан дараах зорилтуудыг дэвшүүлж байна.

1.Төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээний гүйцэтгэлийн төлөвлөгөөг биелүүлэн ажиллах.

2.Нийгмийн даатгалын үйл ажиллагааг гомдол чирэгдэлгүйгээр түргэн шуурхай явуулах, ажлын доголдол гаргахгүй ажиллах.

3.Ажлын хариуцлага санаачлагыг өндөржүүлж нийгмийн даатгалын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ТАСАГ